



Funded by the
European Union

TRANSITION

Ministry of Foreign Affairs of the Czech Republic



Caritas
Czech Republic




Mongolian Youth Council



**Европын Холбооны санхүүжилттэй “Бүгд Залуусын Төлөө, Залуус
Бүгдийн Төлөө” төсөл**

“Тусгал” бүтээлч гэрэл зургийн уралдааны зар



Төслийн тухай: Европын Холбооны санхүүжилттэй “Бүгд Залуусын Төлөө, Залуус Бүгдийн Төлөө” төслийг Каритас Чех Републик (CCR), Иргэний Боловсролын Төв (CCE) болон Монголын Залуучуудын Эвсэл (MYS) хамтран хэрэгжүүлдэг. Энэхүү төслийн ерөнхий зорилго нь залуучуудын хөгжил, оролцооны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын чадавхийг бэхжүүлэн, хамтын ажиллагааны сүлжээ үүсгэн, судалгаа, нөлөөлөл хийх замаар Монгол улсын засаглал, хөгжлийн явцад хувь нэмэр оруулах чадвартай залуучуудын иргэний нийгмийг бэхжүүлэхэд оршино. 2020 оноос хэрэгжиж буй уг төсөл нь Улаанбаатар хот, Хэнтий, Дорноговь, Баянхонгор болон Сэлэнгэ аймаг гэсэн таван зорилтот бүстэй. Уг төслийн үндсэн хэрэгжүүлэгч Каритас Чех Републик 15-34 насны хүүхэд залуусын дунд өөрийн дуу хоолой, хүсэл зоригийг гэрэл зургаар дамжуулан илэрхийлэх ханын зурагтай бүтээлч гэрэл зургийн уралдааныг зарлаж байна.

Танилцуулга

а. Ханын зурагтай бүтээлч гэрэл зургийн зорилго нь Монголын залуу үед тулгардаг асуудлуудыг ил болгож, олны анхаарлыг гэрэл зургаар дамжуулан татах юм. Гэрэл зургийн уралдаанаар дамжуулан уг урлагт хайртай залуусыг дэмжиж, өөрсдийн амьдрал, нийгэмд тулгарч буй асуудлуудыг хуваалцаасай гэж хүссэн билээ. Мөн Европын Холбооны “Бүгд Залуусын Төлөө, Залуус Бүгдийн Төлөө” төслийн үр дүн, амжилтыг гэрэл зургийн урлагаар дамжуулан илэрхийлэх зорилготой тэмцээн.

б. Европын Холбооны санхүүжилттэй “Бүгд Залуусын Төлөө, Залуус Бүгдийн Төлөө” төсөл нь Монголын бүх залуусын сайн сайхан, хөгжил дэвшил, хүртээмжтэй байдлын төлөө үйл ажиллагаа явуулдаг. Боловсрол, ажилгүйдэл, сэтгэцийн эрүүл мэнд, жендерийн эрх тэгш байдал, нийгмийн харилцаа зэрэг залууст тулгардаг гол бэрхшээлүүдийг төрөл бүрийн арга замаар шийдвэрлэх зорилготой болно. Ханын зурагтай бүтээлч гэрэл зургийн уралдаан нь бүтээлч байдал, олон нийтийн өмнө асуудал хөндсөн, Монголын залуусын дуу хоолойг хүргэж байгаа зэргээрээ төслийн хувьд томоохон ач холбогдолтой үйл ажиллагаа юм.

Тавигдах шаардлага

а. Уралдаанд оролцогчдод дараах шаардлагуудыг тавина:

i. Оролцогчид 15-34 настай байх

ii. Аль ч бүсийн харьяат иргэн оролцож болох боловч төслийн зорилтот таван бүс болох Улаанбаатар хот, Хэнтий, Дорноговь, Баянхонгор, Сэлэнгэ аймгуудад зурагдсан ханын зургийг гэрэл зурагтаа багтаасан бол давуу тал болно.

б. Уралдаанд оролцож буй гэрэл зургууд дараах шаардлагуудыг хангасан байх:

i. Төслийн таван зорилтот бүсэд зурагдсан ханын зургуудыг багтаасан бол давуу тал болно. Ханын зургийг арын фон, гол цэг, харилцсан байдлаар гээд ямар ч утга санаа оруулан, бүтээлч байдлаар ашиглаж болно.

ii. Залууст тулгамдаж буй нийгмийн асуудлыг гэрэл зургаараа заавал хөндсөн байх. Залууст түгээмэл тулгардаг ямар нэгэн асуудал бэрхшээл, хүсэл мөрөөдөл эсвэл өдөр тутмын асуудлуудын талаар хөндсөн байх.

Гэрэл зургийн сэдэв

а. Тэмцээний нэр болон сэдэв нь “Тусгал”. Уралдаанаар дамжуулан Монголын залуусын нүүр тулж буй асуудлуудыг тусгахыг тэмцээн зохион байгуулагчдын зүгээс хүсэж буй. Тэмцээнд ажилгүйдэл, эрх баригчдын хайхрамжгүй байдал, шийдвэр болон бодлого гаргах үйл явцад нөлөөлж чадахгүй байгаа, боловсролын чанар, залууст чиглэсэн бодлогын үйл ажиллагаа дутмаг, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нийгмийн бүтэц зохион байгуулалтгүй байдал, сэтгэцийн эрүүл мэнд, цөөнхийн бүлгийн иргэдэд тулгардаг асуудлууд зэргийг тусгасан гэрэл зургуудаа илгээх боломжтой. Нэмэлтээр залуусын оролцоог дэмжиж, шийдэл олж, аз жаргалтай байгааг итгэл найдвар, хүсэл мөрөөдөл, урам зоригтой байгаагаар дүрсэлсэн байвал давуу тал болно.

б. Гэрэл зургийн уралдааны сэдэвтэй холбоотой зөвлөмж болон шалгуурууд:

- i. Гэрэл зураг нь залуустай холбоотой тодорхой асуудлыг хөндөнгөө боломжит шийдэл, эерэг байдлыг дүрсэлж байвал давуу талтай
- ii. Оролцогчид билэг тэмдэг, түүхийн хүүрнэл, зохиомж, гэрэл зураг өнгө будаг ашиглахдаа бүтээлч байхыг уриалж байна
- iii. Гэрэл зургууд ялгаатай байдал, хүртээмжтэй байдал болон Монгол залуусын өөр өөр өнцгийг дүрсэлбэл давуу талтай.

Уралдаанд оролцох заавал

- a. Гэрэл зургуудыг дижитал форматаар хүлээн авна (JPEG юм үү PNG)
- b. Нэг оролцогч дээд тал нь 3 зургийг уралдаанд илгээнэ. Хоёроос дээш зураг илгээхдээ нэг ханын зургийг дүрсэлж болох ч зохиомж, санаа нь дахин давтагдаагүй, өөр өөр байх ёстойг анхаарна үү?
- c. Гэрэл зургуудаа agiimaa.oyun@caritas.cz хаягаар илгээгээрэй. И-мэйлийн гарчигтаа: Тусгал гэрэл зургийн уралдаанд гэсэн нэр өгнө.
- d. Зургаа уралдаанд илгээхдээ дараах мэдээллүүдийг заавал хавсаргана:
 - i. Овог нэр: Өөрийн овог нэрийг зөв бичнэ үү?
 - ii. Зургийн нэр: Илгээсэн зураг болгондоо нэр өгнө үү?
 - iii. Холбогдох дугаар: Тантай холбогдоход шаардлагатай гар утасны дугаар, цахим шуудангийн хаяг зэргийг бичиж илгээнэ үү?
- e. Уралдааны бүтээл хүлээн авах сүүлийн өдөр: 2023 оны 8-р сарын 11 – 18 цаг. Энэ цагаас оройтсон бүтээлүүдийг хүлээн авахгүй тул оролцогчид цагтаа бүтээлээ ирүүлнэ үү.

Ялагчийг тодруулах процесс

- a. Уралдаанд ирсэн бүтээлүүдийг Каритас Чех Републикийн Фейсбүүк хуудсанд байрлуулж, олон нийтээс санал авах болно. Ялагчийг 50% үзэгчдийн санал, 50% төслийн багийнхны үнэлгээгээр тодруулна.
- b. Шалгарсан бүтээлүүдийг шалгаруулах хугацаа:
 - i. Бүтээл хүлээн авах сүүлийн өдөр: 2023 оны 8-р сарын 11 – 18 цаг.
 - ii. Олон нийтийн санал өгөх хугацаа: Бүтээлүүдийг хүлээн авснаас хойш 3 өдрийн дотор Каритас Чех Републик байгууллагын Фейсбүүк хуудсанд нийтлэх бөгөөд 7 хоног байрлуулна. Энэ хугацаанд олон нийт өөртөө таалагдсан зурагт санал өгнө.
 - iii. Төслийн багийн санал өгөх хугацаа: Олон нийт саналаа өгч дуусаад, дараагийн шатны шалгаруулалтыг төслийн багийнхан гаргана.
 - iv. Ялагчийг тодруулах: Олон нийт саналаа өгч дууссаны дараа төслийн багийнхан санал хурааж ялагчдыг тодруулах бөгөөд Фейсбүүк хуудсанд зарлаж, ялагчидтай холбогдон шагналыг нь өгнө.

Шагналын сан

- a. Шагнал: 5

1. Canon EOS 800D мэргэжлийн гэрэл зургийн аппарат х1
2. Skullcandy утасгүй чихэвч х 2
3. 17film lab 500 мянган төгрөгийн гэрэл зургийн сургалтад суух эрхийн бичиг х 2

b. Олон нийтэд алдаршуулах: Шилдэг зургийн эздэд шагнал гардуулахаас гадна бүтээлийг нь төслийн хугацаанд олон нийтэд таниулж, алдаршуулах болно. Цаашид төслийн брошур, веб хуудас, олон нийтийн сүлжээ булан бусад сувгуудаар бүтээлүүдийг нь ашиглах боломжтой. Ингэснээр таны нэртэй бүтээл Монголын залуусын сайн сайхны төлөө хийж буй арга хэмжээнүүдэд үргэлж цуг явах болно.

Оюуны өмчийн эзэмших эрх

a. Эзэмших болох ашиглах эрх: Тэмцээнд гэрэл зургаа ирүүлснээр оролцогчид тухайн зургийг ашиглах эрхийг төслийн багт олгохоор зөвшөөрсөнд тооцно. Гэхдээ төсөл гэрэл зургийг ашиглах үедээ зурагчны нэрийг заавал дурдаж, эрхийг нь хүндэлнэ.

c. Хэвлэн нийтлэх зөвшөөрөл: Оролцогчид гэрэл зурганд дүрслэгдсэн хүмүүсээс шаардлагатай тохиолдолд заавал зөвшөөрөл авна. Гэрэл зурагт танигдахуйц дүрслэгдсэн хувь хүн, үл хөдлөх хөрөнгийн эздээс зураг авах, зургийг тэмцээнд болон төслийн хүрээнд ашиглаж болох эсэхийг асууна. Оролцогч тухайн хүмүүсээс зөвшөөрөл аваагүйгээс үүдэн маргаан үүсвэл төслийн баг ямар нэгэн байдлаар хариуцлага хүлээхгүй болно.